



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 5/08

Ховд

С.Лхамхүүг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.1, Улсын их хурлын 2007 оны 73 дугаар “Улс төрийн албан хаагчийн албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэх тогтоох тухай” тогтоолын 1 дэх заалтууд, Мянгад сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны 7/9 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05/369 дүгээр албан бичгээр хянагдаж ирсэн Самгарьдын Лхамхүүг 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн Мянгад сумын Засаг даргаар томилсугай.

2. С.Лхамхүүг Засгийн газрын 2014 оны 333 дугаар тогтоолын 1 дэх заалтын дагуу 835276 төгрөгөөр цалинжуулж, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийн хэмжээг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар тооцон сар бүр олгохыг Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

3. Мянгад сумын Засаг даргын ажлыг хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох тооцоог хийхийг тус сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ч.Улаанхүүд даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Мянгад сумын Засаг даргын эрх, үүргийг тус сумын Засаг даргын орлогч Мягмаржавын Баянжаргалд хариуцуулсан аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Б/83 дугаар захирамжийн 2 дахь заалтыг 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөр тасалбар болгон хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax B/08Ch
02 00146